

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Дэлхийн газрын гадаргын шинж чанарыг тодорхой үзүүлдэг том масштабын зургийг гэнэ. /1оноо/

- A. Топографи
- B. Гипсографи
- C. Барографи
- D. Картографи
- E. Термографи

2. Агаарт бүрэн шатаж дуусалгүй дэлхийн гадарга дээр унах сансрын биет аль нь вэ? /1оноо/


- A. Хиймэл дагуул
- B. Манан
- C. Солир
- D. Сүүлт Од
- E. Толир

3. Одон орны нэгж аль нь вэ? /1оноо/

- A. 365 сая км
- B. 150 сая км
- C. 30 сая км
- D. 125 сая км
- E. 109 сая км

4. Дөрвөд ястан аль аймагт амьдардаг вэ? /1оноо/

- A. Баян-Өлгий
- B. Завхан
- C. Увс
- D. Сүхбаатар
- E. Ховд



5. Далайн усны түвшинээс доош 200 м хүртлэх гүнд орших эх газрын үргэлжлэл хэсгийг олоорой. /1оноо/

- A. Тал
- B. Ташланга
- C. Хажуу
- D. Ангал
- E. Тан

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

- 1) 2.1 даалгаврын Тэс голын хэвгийг [a,b,c], Ховд голын усны хэвгийг [d,e,f], сонгосон хариултаа [g] эгнээнд тэмдэглээрэй.

Жишээлбэл: эцсийн хариуг [Тэс – 1,7 м/км] , [Ховд – 1,5 м/км] Зөв хариултаас 1 дугаарыг сонгосон гэж үзвэл [a-1] [b-᠑] [c-7] [d-1] [e-᠑] [f-5] [g-1] гэж бөглөнө.

- 2.1. Тэс голын эх нь дтд 2009 м өндөрт, адаг нь дтд 759 м өндөрт оршино. Голын урт 568 км болно. Ховд голын эх нь дтд 3018 м өндөрт, адаг нь дтд 1157 м өндөрт оршино. Голын урт 516 км болно. Хоёр голын хэвгийг (м/км) тооцоолж, алинд нь УЦС барих боломжтойг сонгоорой.

/4оноо/

1. Булнайн нуруунаас эх авч Увс нуурт цутгадаг Тэс гол
2. Хөх Сэрхийн нуруунаас эх авч Хар нуурт цутгадаг Ховд гол
3. Тарвагатайн нуруунаас эх авч Хяргас нуурт цутгадаг Тэс гол
4. “Алтай таван богд”-ын БЦГ-аас эх авч Хар-Ус нуурт цутгадаг Ховд гол

- 2.2. Жолоочид 1 тн ачааг 150 км зайд тээвэрлэх ажлын санал иржээ. Жолооч захиалагчтай 1 тн км ачаа эргэлтийг 1000 төгрөгөөр тээвэрлэхээр тохиролцжээ. 2 тн даацтай Портер машин нь 100 км-т 13 л түлш зарцуулдаг бөгөөд зах зээлийн ханшаар 1 л түлш нь 1780 төгрөг бол жолоочид оногдох цэвэр ашгийг тооцоолж олоорой.

/4оноо/

- 2.3. Нисэж яваа онгоцны гаднах агаарын температур нь -30°C , энэ үед газрын гадаргад 25°C байсан бол онгоц ямар өндөрт нисэж байсан бэ?

/4оноо/

- 2.4. Нигери улс 2012 оны байдлаар 175 сая хүн амтай, хүн амын жилийн дундаж өсөлт нь 1.6% байв. 2030 онд Нигери улсын хүн амын тоо хэдээр нэмэгдсэн байхыг тооцоолж олоорой.

/4оноо/

6. Ф.Магелланы нээсэн газар нутаг аль нь вэ?

/1оноо/

- А. Антарктид, Шинэ Гвиней- Папуа
- В. Австрали, Шинэ-Зеланд, Кенгуру
- С. Гренланд, Лабрадор, Ньюфаундленд
- Д. Полинези, Филиппин, Галт газар
- Е. Америк, Юкатан, Антилийн арлууд

7. Дэлхийн тал бөмбөрцөгийн газрын зургийг зохиоход аль тусгагийг ашиглавал хамгийн бага гажилттай зурагдах вэ?

/1оноо/

- А. Цилиндр
- В. Олон өнцөгт
- С. Конус
- Д. Хөндлөн азимут
- Е. Азимут


8. Эргэн тойрон далай тэнгисээр хүрээлэгдсэн хуурай газрын хамгийн том хэсгийг нэрлээрэй.

/1оноо/

- А. Хойг
- В. Тив
- С. Арал
- Д. Эх газар
- Е. Хошуу

9. Сүхбаатар аймгийн голууд аль далайн ай савд багтах вэ?

/1оноо/



- А. Номхон далай ба Хойд мөсөн далайн ай сав
- В. Энэтхэгийн далай ба Хойд мөсөн далайн ай сав
- С. Хойд мөсөн далай ба Гадагш урсгалгүй дотоодын ай сав
- Д. Гадагш урсгалгүй дотоодын ай сав ба Энэтхэгийн далай
- Е. Номхон далай ба Гадагш урсгалгүй дотоодын ай сав

10. Уулын өндрийг далайн түвшнээс дээш хэмжээнийг юу гэж нэрлэх вэ? /1оноо/

- A. Үнэмлэхүй өндөр
- B. Харьцах өндөр
- C. Тогтмол өндөр
- D. Зэрэгцсэн өндөр
- E. Харьцангуй өндөр

11. Улаанбаатар хотоос шууд нислэг хийдэг хотыг сонгоно уу. /1оноо/

- A. Манила
- B. Осака
- C. Ром
- D. Дели
- E. Дубай

12. Голын хөндийн дагуу тогтсон, эргээсээ мөргөцөгөөр зааглагдсан газрыг гэнэ. /1оноо/

- A. Татам
- B. Дэнж
- C. Голдрил
- D. Меандр
- E. Дельта

13. Эх газар ба далайн хооронд улирлаар чиглэлээ өөрчилдөг салхи аль нь вэ? /1оноо/

- A. Баруун зүгийн салхи
- B. Пассат
- C. Муссон
- D. Фён
- E. Бриз

14. Улаанбуудайн ургац хураалтаар тэргүүлэгч орнуудыг олоорой. /1оноо/

- A. Хятад, АНУ
- B. Канад, Энэтхэг
- C. АНУ, ОХУ
- D. ОХУ, Австрали
- E. Энэтхэг, БНХАУ

15. Нар жилд хоёр удаа эгц тусдаг шугам аль нь вэ? /1оноо/

- A. Туйлийн цагираг
- B. Мэлхийн зам
- C. Экватор
- D. Туйл
- E. Матарын зам

47. “Намнан уул”-ын байгалийн цогцолборт газар нь аль аймгийн нутгийг дамнан оршдог вэ? /2оноо/

- A. Сэлэнгэ, Булган
- B. Хөвсгөл, Архангай
- C. Архангай, Баянхонгор
- D. Булган, Хөвсгөл
- E. Архангай, Завхан

48. Дэлхийн хамгийн шилдэг хот болох Ванкувер хот нь БУ123°-д оршдог бол Улаанбаатар хотоос хэдэн цагийн зөрүүтэй болохыг тооцоолж олоорой. /2оноо/

- A. 15 цаг 18 мин
- B. 14 цаг 18 мин
- C. 16 цаг 18 мин
- D. 17 цаг 18 мин
- E. 18 цаг 18 мин

49. Өмнөд Америкийн газар усны нэрсийг өмнөөс хойш нь зөв байрлуулсныг сонгоорой. /2оноо/

- A. Вальдесын хойг, Патагоны тэгш өндөрлөг, Чилоэ арал
- B. Андын нуруу, Амазонка мөрөн, Маракайбо нуур
- C. Галт газар арал, Пампын хээр тал, Гвианы тэгш өндөрлөг
- D. Титикака нуур, Бразилийн тэгш өндөрлөг, Ориноко мөрөн
- E. Анхелийн хүрхрээ, Каатингын саванн, Парана мөрөн

50. Монгол орны усны сав газруудыг аймагтай нь харгалзуулаарай. /4оноо/

- | | |
|---------------------------|--|
| 1. Говийн хойд-Халхын тал | а. Дорнод, Хэнтий |
| 2. Мэнэн | б. Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь |
| 3. Улз | в. Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Төв |
| 4. Галба-Өөш | г. Сүхбаатар, Дорнод |
| 5. Хэрлэн | д. Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Дундговь, Төв, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий |

- A. 1-д, 2-г, 3-а, 4-б, 5-в
- B. 1-в, 2-б, 3-г, 4-д, 5-а
- C. 1-д, 2-а, 3-в, 4-б, 5-г
- D. 1-в, 2-а, 3-д, 4-б, 5-г
- E. 1-д, 2-в, 3-а, 4-г, 5-б

42. ОХУ-ын Алтайн БНУ, БНХАУ-ын Шинжаан-Уйгурын ӨЗО-той хил залган оршдог аймаг, хилийн гарцыг сонгоорой. /2оноо/

- A. Хөвсгөл, Ханх
- B. Баян-Өлгий, Цагааннуур
- C. Увс, Боршоо
- D. Говь-Алтай, Бургастай
- E. Ховд, Булган

43. “Хөрсний алдагдлыг тооцох нэгдсэн томъёо” нь жилийн дундаж хөрсний зөөгдлийг тн/га нэгжээр хэмждэг бол **K** нь юуг илэрхийлдэг вэ? /2оноо/

- A. Хөрс хамгаалал
- B. Гадаргын өөрчлөлт
- C. Налуугийн градиент
- D. Хөрсний элэгдэх шинж
- E. Хажуугийн урт


A=RKLSCP

44. Филиппины Манила хотод төвтэй 1966 онд байгуулагдсан олон улсын байгууллага аль нь вэ? Энэ байгууллагад Монгол улс 1991 онд элссэнээс хойш шинжлэх ухаан, дэд бүтэц, ХАА-н чиглэлээр олон салбарт хамтран ажиллаж байна. /2оноо/

- A. Азийн хөгжлийн банк
- B. Дэлхийн худалдааны байгууллага
- C. Олон Улсын Валютын сан
- D. Европын холбоо
- E. Дэлхийн банк

45. Дараах график, диаграммыг ажиглаж ямар уур амьсгалтай газар нутаг болохыг сонгоно уу. /2оноо/

- A. Конго мөрний сав газар, БНАКУ
- B. Хавай, Алеутын арлууд, АНУ
- C. Амазонкийн нам газар, Бразил улс
- D. Брахмапутра, Кални гол, Энэтхэг
- E. Ориноко мөрний сав газар, Венесуэль



46. Газар тариалан нь хөрсний доройтлын гол шалтгаан нь болж буй бүс нутаг аль нь вэ? /2оноо/

- A. Хойд Америк
- B. Ази
- C. Төв Америк
- D. Австрали далайн орнууд
- E. Өмнөд Америк

16. Лалын шашны шийтийн урсгалыг хүн амын олонх нь шүтдэг улсууд аль нь вэ? /1оноо/

- A. Афганистан, Азербайжан
- B. Иран, Армен
- C. Армен, Түрк
- D. Азербайжан, Иран
- E. Түрк, Афганистан

17. Дорноговь аймгийн нутагт оршихорд нь 10.6 сая тн зэсийн нөөцтэй. /1оноо/

- A. Цагаан элс
- B. Хар-Айраг
- C. Гурван булаг
- D. Төмөртэйн Овоо
- E. Цагаан суварга

18. Аутсорсинг - Гадаад нөөцийн судалгаа, шинжилгээ, шинэ технологи буюу үйлдвэрлэлийн дөрөвдөгч салбарт хамаарагдах ойлголтыг олно уу. /1оноо/

- A. Худалдаа хийх
- B. Зах зээлээ өргөжүүлэх
- C. Зардлаа бууруулах
- D. Зар сурталчилгаа явуулах
- E. Хөрөнгө оруулалт хийх

19. Солирын бөмбөгдөлтөөс дэлхийг аль нь хамгаалдаг вэ? /2оноо/

- A. Агаар мандал
- B. Үүлний давхраа
- C. Соронзон орон
- D. Хүлэмжийн хий
- E. Озоны давхарга

20. Дараах томъёоны асуултын тэмдгийн оронд тохирох үгийг сонгоно уу. /2оноо/

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин = (? / эдийн засгийн идэвхитэй хүн ам) * 100%

- A. Ажиллагсадын тоо
- B. Нас хэтэрсэн ажиллагсад
- C. Хүмүүн капитал
- D. Бүртгэлтэй ажилгүйчүүд
- E. Хүн амын цонх

21. Завхан аймаг нь 2001 онд УИХ-аар батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-аар эдийн засгийн аль бүсэд багтах вэ? /2оноо/

- A. Баруун бүс
- B. Хангайн бүс
- C. Төвийн бүс
- D. Зүүн бүс
- E. Улаанбаатарын бүс

22. Уулын спортын тамирчин нь 6000 м өндөр оргилд авирахын тулд ямар улсад очих нь зөв бэ? /2оноо/

- A. Австри
- B. Венесуэль
- C. Бирм
- D. Пакистан
- E. Камерун

23. Төвдөө бага даралттай цагийн зүүний эсрэг дээш чиглэсэн агаарын хуйлраа хөдөлгөөнийг гэнэ. /2оноо/


- A. Дулаан фронт
- B. Циклон
- C. Хүйтэн фронт
- D. Агаарын масс
- E. Эсрэг циклон

24. Төв Азийн далайд гарцгүй орнуудын үргэлжилсэн бүсэд багтах улсуудыг олоорой. /2оноо/

- A. Тажикстан, Гүрж
- B. Үзбекстан, Армен
- C. Азербайжан, Балба
- D. Түркмен, Киргиз
- E. Афганистан, Бутан

25. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн бүдүүвчийг гүйцээж нөхөөрэй. /2оноо/

- A. 7 дүүрэг, 1123 баг
- B. 9 дүүрэг, 1568 баг
- C. 9 дүүрэг, 1132 баг
- D. 9 дүүрэг, 2632 баг
- E. 8 дүүрэг, 329 баг



26. Дэлхийн хамгийн өндөр уулсыг олоорой. Н- 9200 м, Н-10 000 м /2оноо/

- A. Мауна-Кеа, Мауна-Лоа
- B. Чогори, Логан
- C. Эврест, Канченжунга
- D. Каракатау, Килауэа
- E. Аконкагуа, Ожос-де-Саладо


27. Азийн хаант засаглалтай улсыг сонгоорой. /2оноо/

- A. Ирак
- B. Сири
- C. Бахрейн
- D. Иран
- E. Армен

39. Ховд болон Говь-Алтай аймгийн хилийг дамнан орших уул нурууг сонгоно уу. /2оноо/

- A. Тарвагатай
- B. Хөх сэрх
- C. Сутай
- D. Хэнтий
- E. Булнай

40. Бүдүүвч дэх 3 ба 6 байршилд тохирох тивийн нэрийн утгыг сонгоно уу. /2оноо/



- A. Нар жаргах зүг, Нар ургах зүг
- B. Нар ургах зүг, Хүний нэр
- C. Хүйтэрдэггүй газар, Нар ургах зүг
- D. Нар жаргах зүг, Эсрэг хойд туйл
- E. Нар ургах зүг, Өмнөд эх газар

41. Байрзүйн зурагт зай болон уртыг хэмжих бол аль багажийг ашиглах вэ? /2оноо/

- A. Анемометр
- B. Курвиметр
- C. Алтиметр
- D. Теодолит
- E. GPS

33. Чи ховор ан амьтан болох говийн аргалийг үзэхээр бол хаашаа явах вэ? /2оноо/

- A. "Монгол дагуур"- ын ДЦГ
- B. "Тосон-Хулстай"- н БНГ
- C. "Их Нарт"- ын БНГ
- D. "Уран уул"- ын БДГ
- E. "Хустайн нуруу"- ны БЦГ

34. НАТО-д гишүүнээр элсээгүй улс орнуудыг сонгоно уу. /2оноо/

- A. Польш, Норвеги
- B. Швед, Швейцарь
- C. Түрк, Португаль
- D. Эстони, Болгари
- E. Румын, Итали

35. Аянга цахилгаантай аадар бороо, мөндөр ордог, зузаан давхаргыг хамарсан маш нягт хар бараан өнгөтэй үүлийг олоорой. /2оноо/

- A. Борооны давхраат
- B. Давхраат бөөн
- C. Борооны бөөн
- D. Давхраат
- E. Өндрийн бөөн



36. Нийт цахилгаан эрчим хүчнийхээ 60%-иас ихийг АЦС-аас гарган авдаг улсуудыг сонгоорой. /2оноо/

- A. Швед, Өмнөд Солонгос
- B. Бельги, Франц
- C. Япон, Швейцарь
- D. Их британи, Япон
- E. Франц, Испани

37. Африкийн эх газрын хамгийн нам цэг (-133 м) аль нь вэ? /2оноо/

- A. Каттарын хонхор
- B. Альмади хошуу
- C. Сомалийн хойг
- D. Мозамбикийн нам газар
- E. Чад нуурын хотгор

38. Номхон далайн баруун захын булан болон улсыг сонгоно уу. /2оноо/

- A. Тонкины булан, Вьетнам улсын эрэг
- B. Бенгалийн булан, Бангладеш улсын эрэг
- C. Бохайн булан, Хятад улсын эрэг
- D. Сиамын булан, Тайланд улсын эрэг
- E. Томиний булан, Индонези улсын эрэг


28. Экваторын бүсийн нарны гэрэл нэвтэрдэггүй мөнх ногоон ширэнгэн ойг..... гэж нэрлэдэг. /2оноо/

- A. Прерий
- B. Саванн
- C. Пампа
- D. Жунгли
- E. Каатинг

29. Финланд улс нь 1914 онд аль улсын колони байсан бэ? /2оноо/

- A. Нидерланд
- B. Орос
- C. Бельги
- D. Испани
- E. Франц

30. Газрын зурагт байгалийн ямар бүс, бүслүүрийг 3 гэсэн цифрээр тэмдэглэсэн бэ? /2оноо/



- A. Хээрийн бүс
- B. Говийн бүс
- C. Уулын бүслүүр
- D. Цөлийн бүс
- E. Ойт хээрийн бүс

31. Малай-Полинези хэлний бүлэгт багтах хэлээр ярьдаг улс аль нь вэ? /2оноо/

- A. Мадагаскар
- B. Вьетнам
- C. Шинэ-Зеланд
- D. Кабо-Верде
- E. Шинэ-Каледони

32. Доломит, гөлтгөнө нь ямар чулуулаг вэ? /2оноо/

- A. Хувирмал
- B. Магмын бялхмал
- C. Тунамал химийн
- D. Тунамал органик
- E. Магмын шургамал